# ОРХОН АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2024.01.08




Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны 04 сарын 06-ны өдрийн А/103 дугаар Программ хангамж ашиглах тухай тушаалыг хэрэгжүүлэн






байгууллагын удирдлагын системийн “Эйбл” программ хангамжийг байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөн аймгийн Засаг даргын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллийн технологийг ашиглан байгууллагуудыг холбох и-оффис системийг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс нэвтрүүлэн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд тус тус ашиглан ажиллаж байна.




Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар (хуучин нэрээр)-ын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг шинэчлэн тус Газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 тушаалаар баталсан Газрын www.egazar.gov.mn цахим системийг ашиглан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газартай холбоотой 17 үйлчилгээг авах хүсэлтийг цахимаа хүлээн авч байна.

Орхон аймгийн хэмжээнд тайлант онд Газрын кадастрын мэдээллийн санд иргэн, хуулийн этгээдээс нийт 4285 хүсэлт ирүүлснээс Баян-Өндөр сум 3821, Жаргалант 464 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

*Аймгийн хэмжээнд нийт ирүүлсэн хүсэлтийг төрлөөр ангилсан байдал.*



Орхон аймгийн хэмжээнд иргэн, хуулийн этгээдээс нийт ирүүлсэн хүсэлтийн 3915 буюу 91.4 хувь нь шийдвэрлэгдсэн, 370 буюу 8.6 хувь шийдвэрлэгдээгүй байна.




Шийдвэрлэгдээгүй өргөдлийн 72.4 хувь нь өргөдөл хүлээн авч бүртгэсэн, 6.2 хувь нь суурин судалгаа хийх, 1.4 хувь нь кадастрын зурагт шинэчлэл хийх, 17.8 хувь нь захирамжийн төсөлд оруулах, 2.2 хувь нь захирамжийн төсөлд явуулах төлөвтэй байна.



Ирүүлсэн хүсэлтийг газар ашиглалтын зориулалтаар ангилж үзэхэд гэр орон сууц, хашааны газрын зориулалтаар 3052, гэр бүлийн зуслангийн газрын зориулалтаар 297, амины орон сууцны зориулалтаар 277 гэсэн үзүүлэлтүүд тэргүүлж байна.

| Д/д | Газар ашиглалтын зориулалт | Тоо |
|---|---|---|
| 1 | 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц | 2 |
| 2 | 5-8 давхар нийтийн орон сууц | 3 |
| 3 | 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц | 8 |
| 4 | Автомашины гараж | 60 |
| 5 | Автомашины засвар, үйлчилгээний газар | 25 |
| 6 | Автотээврийн үйлчилгээний зориулалтын барилга, байгууламж | 1 |
| 7 | Амины орон сууц | 277 |
| 8 | Амралтын газар | 1 |
| 9 | Банк, санхүүгийн байгууллага | 1 |
| 10 | Биеийн тамир, спортын байгууллага | 3 |
| 11 | Боловсролын байгууллага | 9 |
| 12 | Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар | 297 |
| 13 | Гэр бүлийн хэрэгцээнийхээс бусад зуслангийн газар | 1 |
| 14 | Гэр, орон сууцны хашааны газар | 3052 |
| 15 | Дэд бүтцийн байгууллага | 1 |
| 16 | Жимс, жимсгэний усалгаагүй тариалан | 2 |
| 17 | Жимс, жимсгэний усалгаатай тариалан | 3 |
| 18 | Зоорь, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах газар | 2 |
| 19 | Мал эмнэлгийн үйлчилгээний цэг | 2 |
| 20 | Мод үржүүлгийн газар | 1 |
| 21 | Өвөлжөө, хаваржаа | 46 |
| 22 | Өвөл-хаврын бэлчээр | 1 |
| 23 | Терминал (ачиж, буулгах талбай) | 1 |
| 24 | Төмөр замын хамгаалалтын зурвас | 1 |
| 25 | Төмс, хүнсний ногооны усалгаагүй тариалан | 65 |
| 26 | Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан | 66 |
| 27 | Төрийн захиргааны байгууллага | 2 |
| 28 | Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан | 7 |
| 29 | Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж | 1 |
| 30 | Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар | 46 |
| 31 | Үйлчилгээтэй орон сууц | 25 |
| 32 | Үр тарианы усалгаагүй тариалан | 34 |
| 33 | Үр тарианы усалгаатай тариалан | 19 |
| 34 | Үтрэм | 1 |
| 35 | ХАА-н машин, механизмын хашаа, гараж | 1 |
| 36 | ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор | 17 |
| 37 | Хатуу хучилттай зам | 2 |
| 38 | Холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станц | 3 |

| | | |
|---|---|---|
| 39 | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 165 |
| 40 | Хүлэмж, дарлага | 3 |
| 41 | Шатахуун түгээх газар, агуулах | 11 |
| 42 | Эрүүл мэндийн байгууллага | 4 |
| 43 | Эрчим хүч дамжуулах станц | 12 |
| **Нийт** | | **4285** |

-oOo-